



ИРГЭНИЙ НИЙГЭМ, ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗӨВШИЛЦӨЛ

Монгол Улс хүний эрхийн төлөв байдлын талаарх хоёрдугаа илтгэлээ 2015 оны 5-р сарын 5-ны өдөр Женев хотод хуралдсан НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийн (UPR-Universal Periodic Review) Ажлын хэсгийн 22-р хуралдаанаар хэлэлцүүлж, нийт 164 зөвлөмж авсан.

Монгол Улсын Засгийн газар өгсөн зөвлөмжөөс 150 зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх үүрэг амлалт авсан бөгөөд НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөл Ажлын хэсгийн тайланг 2015 оны 9-р сарын 24-ний өдөр хэлэлцэж, баталсан юм.

Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлыг сайжруулах, UPR-ын зөвлөмжийг хэрэгжүүлэхэд бүх талын оролцоо, хамтын ажиллагаа чухал тул өнөөдрийн хэлэлцүүлгийг төрийн болон төрийн бус байгууллага, Хүний эрхийн үндэсний комиссын төлөөлөл, НҮБ-ын Монгол Улс дахь багийн оролцоотойгоор зохион байгууллаа. Тус арга хэмжээнд оролцсон төрийн байгууллага, Хүний эрхийн ТББ-уудын Форумын төлөөлөл болон бусад ТББ-ууд, НҮБ-ын Монгол Улс дахь баг, Хүний эрхийн үндэсний комисс хамтын хүчин чармайлтаар харилцан ойлголцлоо нэмэгдүүлэх, UPR-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр цаашид хамтран ажиллах талаар нухацтай хэлэлцсэний дүнд дараах асуудлаар нэгдсэн ойлголцолд хүрлээ. Үүнд:

- UPR, гэрээний хороод, НҮБ болон олон улсын хүний эрхийн бусад механизмаас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хариуцах Зохицуулах хороог Хүний эрхийн үндэсний комисс, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөлтэйгээр байгуулах, энэ нь Монгол Улс дахь Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн Зохицуулах хороо байж болох тул цаашид судлан үзэх саналыг Засгийн газарт тавих;
- UPR болон бусад механизмаас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт, тулгарч буй хүндрэл бэрхшээлийн талаар жилд 1-ээс доошгүй удаа олон талын оролцоотой хэлэлцэж байх;
- UPR болон бусад механизмаас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх явцад бүх талуудын оролцоог дэмжих;
- UPR зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх Засгийн газрын төлөвлөгөөнд зөвлөмжийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн, хэмжих шалгуур буюу хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа, хариуцах субъектийг тодорхой тусгах.

Улаанбаатар хот

2015 оны 10-р сарын 15